

ЯПОН ДАХЬ МОНГОЛ ТОГТМОЛ ХЭВЛЭЛИЙН (1905-1949)
ХАДГАЛАЛТЫН БАЙЦААЛТ

Доктор, профессор Хөхбаатарын тогтмол хэвлэлийн судалгааны тухай

Отгонбаяр*

Сэчэн**

* Өвөр Монголын Их Сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн Сонин мэдээлэл, хэвлэхүй ухааны салбарын доктор, профессор

** Өвөр Монголын Их сургуулийн дэд профессор

Түлхүүр үг: Монгол тогтмол хэвлэл, бүртгэн данслах, ангилан төрөлжүүлэх, Монгол тогтмол хэвлэлийн хадгалалт

Агуулгын товч

Японы ноёрхлын үед, япончууд хуурмаг Манжийн хойд хэсэгт, тэрчлэн Монгол хязгаарын засгийн харьяанд хүртэл Монгол хэлний тогтмол хэвлэлийг хэвлэхийг дэмжих буюу эрхлэн хэвлэж, түүнийг Монгол орон дахь ноёрхлоо бататгаж, Монголд авах төрийн бодлогоо ухуулахын төлөө үйлчлүүлж байв. Дэлхийн 2-р дайн дууссаны дараа ч тэдгээр тогтмол хэвлэл нь Япон улсын олон номын санд тодорхой хэмжээгээр хадгалагдсаар байна. Үүний тухай эрдэмтэн Хөхбаатар нарийн судалгаа хийжээ. “Японд хадгалагдаж байгаа Монгол тогтмол хэвлэл” хэмээх тодорхой бүртгэл гаргасан байна. Тус өгүүлэл нь эрдэмтэн Хөхбаатарын Япон дахь Монгол тогтмол хэвлэл (1905-1949)-ийн хадгалалтын байцаалтад суурилж, түүний Монгол тогтмол хэвлэлийг бүртгэн данслах, ангилан төрөлжүүлэх, жич Монгол тогтмол хэвлэлийн нэрийдлийг тодруулан судалсан зэрэг судал-

гааны ажилыг системтэй танилцуулан өгүүлэхийг хичээв.

1931 оны “9-р сарын 18-ны хэрэг хувьсгал”-ын дараа япончууд Дундад улсын зүүн хойд орныг бүрмөсөн залгин эзлэв. Японы ноёрхлын үед япончууд хуурмаг Манжийн хойд хэсэгт, тэрчлэн Монгол хязгаарын засгийн харьяанд хүртэл монгол хэлний тогтмол хэвлэлийг хэвлэхийг дэмжих буюу эрхлэн хэвлэж, түүнийг Монгол орон дахь ноёрхлоо бататгаж, Монголд авах төрийн бодлогоо ухуулахын төлөө үйлчлүүлж байв. Дэлхийн 2-р дайн дууссаны дараа ч тэдгээр тогтмол хэвлэл нь Япон улсын олон номын санд тодорхой хэмжээгээр хадгалагдсаар байна. Жишээлбэл Токио дахь Тоио бүикү номын санд 1908 оноос 1940-өөд оны хооронд монгол хэлээр хэвлэгдсэн тогтмол хэвлэл 19 төрөл хадгалагдаж буй, хуурмаг Манжийн үед хэвлэгдсэн “Хөх туг” ба түүнээс өмнө хэвлэгдэж байсан Мүгдэний Монгол сэтгүүл зэрэг хэдэн төрлийн монгол сонин сэтгүүлийг Японы Осака гадаад хэлний их сургуулийн номын сангийн Ишихама Бүикү олон тоогоор хадгалагдаж байна.

1987 онд ӨМӨЗО-ы номын сангаас хэвлүүлсэн "Улс байгуулагдахаас өмнөх Өвөр Монголын орон дахь сонин сэтгүүлийн магадлалт"-д улс байгуулагдахаас өмнөх монгол хэлний тогтмол хэвлэл 74 хувийг магадлан тодруулав. Үүнд одоо болтол хадгалагдаж байгаа нь тодорхой мэдэгддэгээс сонин 14 хувь, сэтгүүл 14 хувь гэх тэмдэглэл харагдана. Хадгалалтын нормоос үзвэл, энэ нь тус номд магадлан тодруулсан бүх тогтмол хэвлэлийн зөвхөн 37.8 хувийг л эзлэнэ. Эдгээр тогтмол хэвлэлийн хадгалалтын тодорхойгүй байдал нь монгол тогтмол хэвлэлийн материалын ашиглалтад туйлын ашиггүй хүчин зүйл болсон байна. Иймээс монгол тогтмол хэвлэлийн хадгалалтын байдлыг магадлан тодруулж, түүнийг судалгааны эх хэрэглэгдэхүүн болгон ашиглах нь судлаачдын өмнөө тавьсан тэргүүн чухал явдал болж байв.

Японд монгол тогтмол хэвлэлийн хадгалалтыг хайх ажлыг өрнүүлж мэдэгдэхүйц амжилт олсон хүн бол Өвөр Монголын нутагтай Шуоба эмэгтэйн их сургуулийн профессор, доктор Хөхбаатар билээ. Тэрээр 1990-ээд оны тэргүүн хагасаас эхэлж 1905-1950 оны хооронд Дундад улсад хэвлэгдсэн монгол хэлний тогтмол хэвлэлийг системтэй цуглуулан эмхэтгэх ажлыг гүйцэтгэсэн билээ.

Хөхбаатар Өвөр Монголын Шилийн гол аймгийн Шулуун хөх хошууны хүн. 1983 онд Гурун их сургуулийн гадаад хэл, уран зохиолын салбарыг төгсч, 1990 онд Японы Осака гадаад хэлний их сургуульд мастер цол хамгаалжээ. 1990 оноос Токио дахь Күтоцубаши их сургуульд суралцаж 1998 онд доктор цол хамгаалсан байна. Түүний доктор цол хамгаалсан өгүүлэл "Хятад хэлний нөлөөн дэх монгол хэлний орчин үеийн үгсийн сангийн бүрдэл. Дундад улсад хэвлэгдсэн монгол тогтмол хэвлэлийн хөгжлийн түүхтэй холбогдуулан судлах нь" нь шинэ Дундад улс байгуулагдахаас өмнө хэвлэгдсэн монгол тогтмол хэвлэлийн материалд суурилж, орчин

үеийн монгол хэлний үгсийн сангийн бүрдлийн асуудлыг нийгэм, хэл шинжлэлийн талаас судалсан байна. Тэрээр материалыг бүрэн эзэмшихийн төлөө урьд хожид Японы Токио, Осака, Киото, Тебару зэрэг хот ба Дундад улсын Өвөр Монголын эл хот, Бээжин, Шанхай, Нанжин, Чанчунь, Шиньян, Далиан, Харбин, Үрэмч, Монгол улсын Улаанбаатар, Орос, Германы зарим хотоор явж, монгол тогтмол хэвлэлийн хадгалалтыг сүвэгчилэн хайв. Энэ хугацаанд тэр монгол тогтмол хэвлэлийг цуглуулан эмхэтгэх талаар доорх мэт бүтэмжтэй ажлыг гүйцэтгэжээ.

Нэг. Улс байгуулагдахаас өмнө хэвлэгдсэн монгол тогтмол хэвлэлийг бүртгэн данслав

Доктор Хөхбаатарын улс байгуулагдахаас өмнө хэвлэгдсэн Монгол тогтмол хэвлэлийг бүртгэн цуглуулах ажлыг Японы эл номын сангийн хадгалалтыг урвуулан нийтлэхээс эхэлжээ. Тэрээр Токиогийн Тоио Бүикү, Осака гадаад хэлний их сургуулийн номын сангийн Ишихама Бүикү зэрэг газар материал хайх явцдаа Дундад улсын хараахан мэдэгдэхгүй (эсвэл хадгалагдаагүй) Монгол тогтмол хэвлэлүүдийг хайн илрүүлэв. Түүний дараа түүний судалгааны ажил нь Дундад улсын эл хот ба Монгол улс зэрэг гадаад улсуудад явагдсан байна. Энэхүү ажлын үр дүнд доктор Хөхбаатар анхны Шадун (1996) онд эдгээр газрын номын сан, данс эвхмэлийн газарт хадгалагдаж байгаа 1905-1950 он хүртэлх Монгол тогтмол хэвлэлийг 102 төрөл бүртгэн данслав. Үүнд Чин улсын сүүлч үе (1905-1910)-ийн сонин сэтгүүл 2 төрөл, Иргэн улсын үе (1912-1948)-ийн сонин сэтгүүл 37 төрөл, хуурмаг Манж улс (1938-1944)-ын үеийн сонин сэтгүүл 10 төрөл, Монгол хязгаарын засаг (1938-1944)-ийн үеийн сонин сэтгүүл 10 төрөл, ӨМӨЗО байгуулагдахын урьд хожид (1945-1951)-ын үеийн сонин сэтгүүл 32 төрөл, бусад үе (1905-1951)-ийн сонин сэтгүүл 11 төрөл

гэх мэт нийт 102 төрөл байлаа. Үүнээс өмнө ӨМӨЗО-ы номын сангаас хэвлүүлсэн “Улс байгуулагдахаас өмнөх Өвөр Монгол орон дахь сонин сэтгүүлийн магадлалт”-д улс байгуулагдахаас өмнөх монгол тогтмол хэвлэлийг хэдийгээр 74 хувь байхыг магадлан тодруулсан боловч, эл газрын номын сан зэрэг материалын хадгалалтаас хайж олсон нь зөвхөн 28 төрөл л байлаа. Хөхбаатарын бүртгэл нь өнгөрсний хүмүүсийн бүртгэлийг 3.6 дахинаар давсан төдийгүй, тогтмол хэвлэл бүрийн хадгалагдаж байгаа газар, хэвлэгдсэн он жил, хэвлэлийн дугаар зэргээр нь нарийн бүртгэн тэмдэглэсэн болохоор хожмын хүмүүс ашиглахад маш дөхөм болжээ. Түүний бүртгэлийг үндэслэвэл монгол тогтмол хэвлэлийн хадгалалт 10 төрлөөс дээш байх номын сан хийгээд данс эвхмэлийн газарт ӨМӨЗО-ы номын сан, Токио дахь Тоио Бүикү, Токио их сургуулийн дорно дахины соёл судлах газар дурдагдана.

Энд олзуурхан тэмдэглэх нь, доктор Хөхбаатар Тоио Бүикүгээс Гүрүний дайчлан байцаах хүрээнээс 1908 онд хэвлэж эхэлсэн “Монгол үгсийн бодрол” (хожим нь “Монгол үгийн бодрол” болов) сэтгүүлийг нийт 23 хугацаа илрүүлсэн нь түүний сүүлч үеийн “Монгол хэлний орчин үеийн үгсийн сангийн бүрдэл”-ийн судлалд үндэс суурийг тавих чухал үйлдлийг үзүүлсэн байна. Түүний “Дундад улсад хэвлэгдсэн хуучин монгол тогтмол хэвлэлийн хадгалалт ба судалгааны байдал” гэх өгүүлэлд тэмдэглэснийг үндэслэвэл, доктор Хөхбаатар “Монгол үгийн бодрол” сэтгүүлийн материалд суурилж “Монгол хэлний орчин үеийн үгсийн сангийн үүсэл бүрдлийн эх сурвалж – Монгол үгийн бодрол” гэх таван ширис өгүүллийг нийтлүүлэв. Эдгээр өгүүлэлдээ Хөхбаатар хятад үгийг махчилан орчуулахаас эхэлсэн монгол хэлний орчин үеийн үгсийн сангийн үүслийн асуудлыг өгүүлэв.

Хоёр. Улс байгуулагдахаас өмнө хэвлэгдсэн Монгол тогтмол хэвлэлийг ангилан төрөлжүүлэв

Материалыг эмхэтгэн цуглуулахад материалыг төрөлжүүлэн ангилах асуудал холбогдоно. Улс байгуулагдахаас өмнө хэвлэгдсэн монгол тогтмол хэвлэлийг цуглуулан эмхэтгэж, судалгааны эх хэрэглэгдэхүүн болгон ашиглахад түүнийг цэгцлэн системжүүлж, ангилан төрөлжүүлэх хэрэгцээ шаардагдана. Тэр нь материалын ашиглалтын норм хийгээд үр бүтээмжийг дээшлүүлэхээс холбогдолтой юм. Доктор Хөхбаатар улс байгуулагдахаас өмнө хэвлэгдсэн Монгол тогтмол хэвлэлийг ангилан төрөлжүүлэхдээ сэтгүүлийг эрхлэн хэвлүүлж байсан төр гүрэн сэтгүүлийн хэвлэгдэж байсан цаг үеийн адил бусыг үндэслэн ангилан төрөлжүүлэх аргыг хэрэглэжээ. Энэ нь одоо үеийн Монгол зуучийн эх үндэс болох Монгол тогтмол хэвлэлийн хөврөлийн үеийн цаг төрийн ороо бусгаа байдлаас шалтгаалагдсан юм. 20 дугаар зууны өмнө хагасын охорхон 50 жилийн хугацаанд монголчууд урьд хожид Орос, Японы ноёрхолд эрхшээгдэж, Чин улс, Иргэн улс, Хуурмаг Манж, Монгол хязгаар засгийн үе зэрэг цаг төрийг туулан өнгөрчээ. Энэ хугацаанд Өвөр Монголын газар зүйн байршил хийгээд Монголчуудын түүхэнд үзүүлсэн онцгой үйлдлээс болж аль нэгэн төр ч бүр Монголчуудыг суртал ухуулгаар илбэн дагуулах ажилыг ихээр хүндэтгэн үзэж байв. Үүний улмаас тогтмол хэвлэл нь тэд нарын улсын төрийн зорилтоо ухуулах, Монголын нийгмийг тогтоон байлгахын чухал багаж хэрэглүүр болж ашиглагдаж байв. Үүний 1905-1949 он болтолх хугацаанд гагцхүү Дундад улсын хил хязгаарт зуу гаруй төрлийн Монгол тогтмол хэвлэл хэвлэгдэн гарсан, явдал гэрчлэх болно. Эдгээрийн дотор олонх тогтмол хэвлэл нь төр засгийн талаас эрхлэн хэвлүүлж байсан буюу түүний нөлөөн дор хэвлэгдэж байсан сонин сэтгүүл болох юм. Жишээлбэл, Гүрүний дайчлан байцаах

хүрээнээс эрхлэн хэвлүүлсэн "Монгол үгийн бодрол" Дон Жи төмөр замын хамааралтын хэлтсээс эрхлэн хэвлүүлсэн "Монголын сонин бичиг" Иргэн улсын засгийн газраас хэвлүүлсэн "Ихэд нийтлэх Монгол бичгийн сэтгүүл" зэрэг дурдагдана. Иймээс доктор Хөхбаатараас Монгол тогтмол хэвлэлийн хэвлэгдсэн түүхийн цаг үеийг нь үндэслэж, улс байгуулагдахаас өмнө Дундад улсад хэвлэгдсэн Монгол тогтмол хэвлэлийг А) Чин улсын засгийн газраас хэвлүүлсэн тогтмол хэвлэл (1908-1911), В) Оросын талаас хэвлүүлсэн тогтмол хэвлэл (1909-1919), С) Иргэн засгийн газраас хэвлүүлсэн тогтмол хэвлэл (1912-1949), D) Япон, Хуурмаг Манж талаас хэвлүүлсэн тогтмол хэвлэл (1945-1950) гэж ангилан төрөлжүүлсэн байна.

Ангилал зүйн үүднээс үзвэл, Хөхбаатарын улс байгуулагдахаас өмнө хэвлэгдсэн Монгол тогтмол хэвлэлийн тухай иймэрхүү ангилал нь нилээд шинжлэх ухааны ангилал болсон байна. 2001 онд Футаки Куруши "Монгол хязгаарын засгийн үеийн Монгол хэлний тогтмол хэвлэлийн тухай" 2007 онд Куросава Сахо "Манж улсын Монгол хугацаат хэвлэгдэхүүний систем хийгээд түүний хөгжил" гэх өгүүлэл нийтлүүлж, тус тус хуурмаг Манжаас хэвлэгдсэн Монгол тогтмол хэвлэл ба Монгол хязгаарын засгийн газраас хэвлүүлсэн Монгол тогтмол хэвлэлийг шинжлэн судалсан байна. Судалгаан дахь Футаки Куруши хийгээд Куросава Сахо-гийн улс байгуулагдахаас өмнө Дундад улсын хил хязгаарт хэвлэгдсэн Монгол тогтмол хэвлэлийн тухай ангилал нь Хөхбаатарын ангилалтай адилавар байна. Иймэрхүү үзэгдэл бол гэнэтийн тохиолдол биш, харин шинжлэх ухаанч оврын судалгааны тавцан дахь хамтын илрэл болох юм.

Гурав. Улс байгуулагдахаас өмнө хэвлэгдсэн Монгол тогтмол хэвлэлийн нэрийдлийг судлан нотлов

Монгол сонин сэтгүүлийн түүхэнд "сэтгүүл" гэдэг үг нь одоогийн "сонин" ба "сэтгүүл"-ийн аль алийг ч заадаг байв. 1909 онд хаант Оросын нөлөөгөөр хэвлэгдсэн хагас сарын сэтгүүл "Монголын сонин бичиг" нь 1912 оноос сонины хэлбэрээр хэвлэгдэх болсны дараа ч нэрийдэл нь халагдаагүй явдал нь үүнийг гэрчилнэ. Энэ нь хятад хэлний нөлөөг хүртсэнээс болсон байна. Хятадын сонин сэтгүүлийн түүхэнд "сонин" хийгээд "сэтгүүл"-ийг бао буюу ганг гэж нэрлэдэг байв. Сонин сэтгүүлийн хөгжлийн явцад хожим нь бао хийгээд ганг нь нарийн утгын ялгаа үүсч, хятад хэлээр "сонин"-ыг баожи "сэтгүүл"-ийг чиган гэж нэрлэх болж, бас хожим нь япон хэлний нөлөөгөөр "сэтгүүл"-ийг зажи гэж нэрлэдэг болжээ. Үүний тухай Хөхбаатар, Монгол хэлний тогтмол хэвлэлийн нэрийдлийн судлалтайгаа холбогдуулан өгүүлсэн бөгөөд монгол хэлний сонин сэтгүүлийн түүхэнд "сонин" хийгээд "сэтгүүл" нь адил нэгэн ухагдахууныг илтгэдэг байснаар барахгүй, бас "бодрол", "дармал" гэх үг нь ч адил төрлийн тогтмол хэвлэлийг нэрлэн заадаг байсан зэргийг тодорхойлов. Доор Хөхбаатарын монгол тогтмол хэвлэлийн нэрийдлийн тухай судлалыг нарийн танилцуулав.

Доктор Хөхбаатарын эн тэргүүнд орчин үеийн үгсийн сангийн судлалын үүднээс "бодрол", "сэтгүүл", "дармал", "сонин" гэх үгийн ирэлтийг хайв. (1) "Бодрол" гэдэг үг "айлтгал" гэдэг үгтэй ойролцоо утгаар хэрэглэгддэг байв. "Бодрол бичиг" гэж олон хэрэглэгддэгээс гадна, бодрол гэж ч бичдэг. Бодрол нь "мэдээлэх" гэдэг салбарласан утгатай байсан болохоор бао-ийн орчуулгын хувьд сонин сэтгүүлийн нэрийдэл болох боломжтой байв. (2) Сэтгүүл гэх үг мэдээлэх гэх утгатай байв. Чин улсын гадаад Монголын төрийг засах явдлын хэлтэсээс хянан тогтоосон "Монгол үсгийн хураангуй" толь бичигт сэтгүүлийг "мэдүүл", "хайгуул", баярын чимээ дамжуулах гэх

зэргээр тайлбарлав. 1913 оны үеэс сэтгүүл нь тогтмол хэвлэлийн нэр болон хэрэглэгдэх болов. Үүнтэй холбогдуулан 1905 онд Гүнсэnnоровын гаргасан нялх сониныг Өвөр Монголд "Нялх" сэтгүүл гэж нэрийддэг нь түүний хятад нэрийнх нь орчуулга болох үндэслэлтэй гэдгийг чухалчлан дурджээ. (7), (3) "Дармал" гэдэг үг нь анхандаа "дармал бүс" гэх мэтээр бүс буюу цаасан дээр үсэг буюу зураг дармаллахын зааж байв. 1910-аад оны сүүлч, 1920-оод оны эхээр хятад хэлэнд ганг "дармал" гэдэг үг нь тогтмол хэвлэлийг заадаг болов. Хятад хэлний нөлөөгөөр Өвөр Монголын "дармал" гэдэг үгээр одоох утга дахь сэтгүүлийг заах болжээ. (4) Сонин гэдэг үг нь "шинэ", "сэвүүн" гэх утгыг илтгэж, үргэлж "шинэ үг", "сэвүүн үг" гэх хэлбэрээр хэрэглэгддэг байв. Хожим нь буриад Монголын

Сонин бичиг, Сонинт бичиг, Дэвтэр сонин гэх үгийн нөлөөгөөр ар Монгол буюу БНМАУ-д одоогийн Сонины утгаар хэрэглэх болж, Дэлхийн хоёрдугаар дайны дараа Өвөр Монгол оронд хэрэглэгдэх болжээ.

Дараад нь бодрол, сэтгүүл, дармал, сонин гэх нэрийдлийн улиран хувирсан явцыг нотлов. (1) Бодрол гэдэг үг нь 1910 он болтол Монгол тогтмол хэвлэлийн нэрийдэл байв. 1908 онд хэвлэл эхэлсэн Монгол үсгийн бодрол бол бодрол гэх үгээр нэрийдсэн хамгийн анхны монгол тогтмол хэвлэл болно. 1910 оноос 1934 оны хооронд тус үг сэтгүүлийн нэрийдлийг заахаа болиов. 1934-1945 оны Хуурмаг Манжийн үед тус үг дахин сэргэв. Түүний сэргэх болсон нь эзэн хаантай холбогдох тус

үгний утгаас болсон тул 1945 онд Хуурмаг Манж улсын мөхлийг дагалдан тус үг нь Монгол үсгийн сан дахь байршилаа алдав. (2) Чин улсын төр мөхсөний дараа "Монгол үгийн бодрол"-ын нэр нь хувирсан бөгөөд "Ихэд нийтлэх Монгол бичгийн сэтгүүл" зэрэг хэвлэл эхэлсэн байна. Энэ үеэс сэтгүүл гэдэг үг тогтмол хэвлэлийн нэр болж, бодрол гэх үгийг орлов. Улс бай-

гуулагдахаас өмнөх нэг хугацаанд сэтгүүл нь одоогийн сэтгүүл ба сониныг хамтад нь заадаг байв. Жишээлбэл, өдрийн сэтгүүл, 7 өдрийн сэтгүүл, 10 өдрийн сэтгүүл, сарын сэтгүүл гэх мэт. (3) 1929 оны 4-р сард Монгол хошуунд тараах 10 өдрийн дармал хэвлэл эхлэв. Энэ үеэс Монгол тогтмол хэвлэлийн нэрийдэлд бас нэгэн шинэ нэр нэмэгдэв. Тус хэвлэл 1929 оноос

«

Хөхбаатар Монгол хэлний тогтмол хэвлэлийн нэрийдлийн судлалтайгаа холбогдуулан өгүүлэхдээ монгол хэлний сонин сэтгүүлийн түүхэнд "сонин" хийгээд "сэтгүүл" нь адил нэгэн ухагдахууныг илтгэдэг байснаар барахгүй, бас "бодрол", "дармал" гэх үг нь ч адил төрлийн тогтмол хэвлэлийг нэрлэн заадаг байсан зэргийг тодорхойлов.

»

аваад 1947 он болтол "Дармал" гэж нэрлэгдсэн сэтгүүл 15 төрөл бий. Энэ цаг үед ар Монгол нэгэнт тусгаар тогтносон тул БНМАУ-д "Дармал" хэмээх тогтмол хэвлэлийн нэр байдаггүй. (4) Сонин гэдэг үг нь дээр дурдсан мэт Өвөр Монголд Дэлхийн хоёрдугаар их дайны дараа одоох утгаар хэрэглэгдэх болжээ. Хуурмаг Манжийн үед Япон хэлний шинбон замши-ийн нөлөөгөөр Өвөр Монголд хэрэглэхгүй байв. Монголчууд сонин ба сэтгүүлийн төрлийг ялгадаг болсон байна.

Дөрөв. Хуучин Монгол тогтмол хэвлэлийн хадгалалт ба судалгааны байдлыг судлав

2007 онд, Хөхбаатар Дундад улсын хил хязгаарт хэвлэгдсэн "Хуучин

Монгол тогтмол хэвлэлийн хадгалалт ба судалгааны байдал” хэмээх тусгай өгүүлэл бичиж, тухайн асуудлын тухай дотоод гадаадын сэтгүүлийн үе хүртэлх судалгааг ерөнхийд нь танилцуулжээ.

(1) Хадгалалт ба судалгааны үндсэн байдал. Хадгалалтын тухай, Дундад улсад судалгааны ба номын сангийн бүртгэл нь бодьтой хадгалалттайгаа маш ихээр зөрөөтэй байгааг өөрийн байцаан судалгаагаараа гэрчлэн үзүүлэв.

(2) Шинэ ба хуучин гэдэг цаг үеийн ангилал. Энд монгол тогтмол хэвлэлийн шинэ, хуучны ангиллын тухай өөрийн үзэлдээ илэрхийлж, Өвөр Монголын тогтмол хэвлэлийн хувьд шинэ нь Дэлхийн хоёрдугаар дайны дараа буюу 1947 оноос хойш байх нь зүйтэй гэдэг саналыг дурдав.

(3) Монгол тогтмол хэвлэлийн хэвлэгдсэн цаг үеийн байдал ба ангилал. Үүний тухай дээр нэгэнт дурдав.

(4) Түрүүчийн хүмүүсийн судлал. Нэгдүгээрт, БНМАУ-ын эрдэмтэн Г.Дэлэгийн “Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл” (1965 он, Улаанбаатар), түүний “Монголын хэвлэл 1940-1970” (1971 он, Улаанбаатар) зэрэг судалгааг товойлгон дурдаж, энэхүү судалгаа нь сонин мэдээллийн судлалын хувьд Монгол улсын байр суурийн үүднээс өгүүлж, бас Дундад улсад хэвлэгдсэний анхны үеийн Монгол тогтмол хэвлэлийн Монгол улс ба ЗХУ дахь хадгалалтын тухай чухал мэдээ хангасан талыг үнэлэв. Хоёрдугаарт, ӨМӨЗО-ы номын сангаас найруулсан “Улс байгуулагдахаас өмнөх Өвөр Монголын орон нутгийн сонин сэтгүүлийн судлал” нь түймрийн хувь хүний бүтээл болох бөгөөд Монгол тогтмол хэвлэлийн судлал дахь түүний эзлэх байр суурь ба үр дүн, ач холбогдлыг үнэлэхийн дагуу, тус номын дутмаг талыг гурван талаар дурдав. Гэхдээ, тэр нь зохиолчийн судалгаанаас шалтгаалагдсан биш, Дундад улсын байдал ба судлагда-

хууны төвөгтэй байдлаас болсныг тодорхойлов.

(5) Зохиолч (Хөхбаатар)-ийн судалгаа (нэг). Энд зохиолч өөрийн докторын цол хамгаалсан өгүүллээ багтаан, монгол тогтмол хэвлэлийн тухай зургаан өгүүлэл ба илтгэлээ товч танилцуулав.

(6) Зохиолч Хөхбаатарын судалгаа (хоёр). Үүнд зохиолчоос “Монгол хэлний орчин үеийн үгсийн сангийн эх сурвалж (Монгол үгийн бодрол) сэтгүүл” судлалын таван өгүүллээ танилцуулсан байна. Зохиолч түүний дараа энэхүү судалгааныхаа зургаа дахь өгүүллээ нийтлэсэн байна.

(7) Доктор Хөхбаатарын улс байгуулагдахаас өмнө хэвлэгдсэн Монгол тогтмол хэвлэлийн хадгалалтын байцаалт хийгээд бүртгэл нь Монгол тогтмол хэвлэлийн судалгаанд материалын цуглуулгыг системтэй хийж, хэвлэлд холбогдсон тухайн үеийн нийгмийн сураг зангийг одоо үед дамжуулж, эрдэм шинжилгээний солбицол судалгаагаар Монгол хэлний судлал, Монгол уран зохиолын судлал, Монгол түүхийн судлал, Монгол сонин сэтгүүлийн судлал зэрэг судалгааг ахиулахад бодитой ач холбогдолтой гэдгийг энд чухалчлан дурдмаар байна.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Гэрэлт Б. 1985. Монгол зохиолчдын шүүмж зохиолууд (1721-1945). Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо.
2. Сүюүгэ. 2005. Намайгийн өгүүллэ шүүмжийн түүвэр. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо.
3. Дэлэг Г. 1965. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ.
4. Дэлэг Г. 1971. Монголын хэвлэл. 1940-1970. УБ.

Резюме

В настоящей статье авторы затрагивают проблемы газет и журналов, издаваемых японскими оккупационными властями на севере Маньчжурии, в марионеточном государстве Маньчжоу-Го и во Внутренней

Монголии. Эти издания использовались японцами как средство укрепления своей власти на этих территориях, агитации и пропаганды силы и мощи Страны Восходящего Солнца. Также они всячески поощряли прояпонски настроенные местные издания. После поражения Японии во Второй мировой войне многие номера этих

газет и журналов хранятся в японских библиотеках и архивах и были исследованы учёных Хохбаатаром из Внутренней Монголии. Также авторы предприняли попытку оценить вклад, который внёс Хохбаатар в развитие исследования монгольской журналистики.